

“ЖИМС, ЖИМСГЭНЭ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Сайншанд

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. Жимс, жимсгэнийн аж ахуйг хөгжүүлэх, таримлын болон бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, говийн нөхцөлд жимс, жимсгэнэ тариалах, ургац хадгалах, боловсруулахад сургах, дадлагажуулах							
1		1.1. Жимс, жимсгэнэ, тарвас тариалах, хураах, хадгалах технологи, хөрс, бордоо, ургамал хамгаалал, сортын суулгац үржүүлэг, усжуулалт, механикжуулалтийн талаар иргэдэд сургалт хийж, мэдлэгт чадварыг сайжруулах	2018 - 2022			<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийг иргэд, ногоочдод танилцуулах, сурталчлах ажлын хүрээнд 7 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж 317 иргэнийг хамруулан, жимс, жимсгэнэ, тарвас тариалах, хураах, хадгалах технологи, хөрс, бордоо, ургамал хамгаалал, сортын суулгац үржүүлэг, усжуулалт, механикжуулалтийн талаар иргэдийн мэдлэгт чадварыг дээшлүүлсэн. Уг хөтөлбөрийг сурталчлах өдөрлөгийг 4 удаа зохион байгуулсан.</p> <p>“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” уриан дор зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд”, “Алтан намар” улсын үзэсгэлэн худалдаанд 8 удаа “Дорноговийн нутагшсан сортын тарвас”-ыг сурталчлан, амталгаат худалдаа явуулсан.</p> <p>Улсын газар тариалан судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн жимс, жимсгэний секторын эрдэмтэдтэй хамтран Монгол оронд сүүлийн таван жил нутагшуулж буй монос, интоор, давжаа алим, бэсрэг алим, чавганы суулгацыг иргэдийн захиалгын дагуу татан авч тариалсан. Мөн хамгаалагдсан хөрсөнд гүзээлзгэнэ тариалан туршиж 0,6 тонн ургац хураан авсан.</p>	100%
2		1.5. Залгаж ургуулах аргаар үрт болон яст жимсний үржүүлэг хийх, талбайд болон хүлэмжид жимс, жимсгэнэ тариалах, мод, бутны таналт, тайралт,	2018 - 2022			<p>Замын-Үүд сумын ойн ангитай хамтран "Мод тарих аргачлал, арчилгаа хамгаалалт, үрийн нөөц бүрдүүлэх, хадгалах" технологийн сургалт, "Гарааны Монгол экологийн бордоо" ХХК, хөдөө аж ахуй, ойн тэнхимийн багш Р.Гэрэлчимэг аймгийн Агропарктай хамтран "Мод үржүүлгийн талбайг байгуулах, арчилгаа хамгаалалт, био бордоо үйлдвэрлэх" сэдэвт сургалтыг явуулж, бордооны зохистой хэрэглээ, үхрийн нүд, бүйлс, гүйлс, улиас тарих арчлах чиглэлээр 68</p>	50%

		хэлбэржүүлэлтийг зохистой хийх арга технологийг эзэмшүүлэх чиглэлээр сургалтад хамруулж шинэ технологитой танилцах, туршлага судлах, тэдгээрийг нэвтрүүлэх;			иргэн, аж ахуйн нэгжид мэдлэг олгосон.	
3		1.6. Жимс, жимсгэнэ тариалж ажлын байр олгосон иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөр, зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах;	2018 - 2022		Жимс, жимсгэнэ тариалж ажлын байр олгосон иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөр, зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах буй “Монгол орны хуурай бүс нутгаас үүдэлтэй элсэн болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах” төслийн дагуу 5 га талбайд ойн зурвас, 1 га талбайд дуслын болон намираа усалгааны системийг нэвтрүүлэн хайлаас, хармаг, агч, чацаргана, буйлс, харгана, жигд, нарс, өрөл зэрэг 8 төрлийн 40 кг үрийг мод үржүүлгийн газрын талбай 64 метр квадрат зуны хүлэмжид тариалан туршсан ба шинээр 9 ажлын байр бий болсон. Монгол Улсын Засгийн газраас 3 хувийн хүүтэй 24 сарын хугацаатай зээл олгохоор шийдвэрлэж 4 иргэн, 1 хоршоонд 69,6 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 3 иргэнд 55,0 сая төгрөг нийт 124,6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	100%
4		1.7. Жимс, жимсгэнэ тариалдаг иргэн, аж ахуйн нэгжид өртгийн сүлжээний санхүүжилтийн талаар таниулах, сурталчлах,	2018 - 2022		Хөдөө аж ахуйн салбарыг кластераар хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулсан. Уг хөтөлбөрийн төсөлд газар тариалангийн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлж, өртгийн сүлжээг бий болгох, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зорилтууд тусгагдсан. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, яамны судалгаа хөгжлийн төв, Дэлхийн зөн олон улсын байгууллагын “гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй” төсөлтэй хамтран “Газар тариалангийн үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэх нь” сургалт, зөвлөгөөнийг Сайншанд суманд 3 дугаар сарын 25, 26-нд зохион байгуулж, сумдын Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон аймгийн газар тариалан эрхлэгчид нийт 65 иргэнийг хамруулан мэдлэг мэдээлэл өгсөн. Сургалтын эхний хагаст яамны судалгаа хөгжлийн төвийн ахлах	100%

					<p>мэргэжилтэн С.Нандинцэцэг "Газар тариалангийн зохистой дадал, ач холбогдол, бүртгэл, хөтлөлт", "Газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүнд Хөдөө аж ахуйн зохистой дадлын баталгаажуулалт олгох үйл явц" сэдвүүдээр, ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн доктор Т.Дэжидмаа "Элементүүд ба Ургамал хамгааллын цогц арга", "Бордоог зохистой хэрэглээ" сэдвээр тус тус сургалт мэдээлэл өгч "Хүлэмжийг аж ахуй эрхлэлт", "Ургамал хамгаалалын гарын авлага", "Хүнсний ногооны голлох таримлын агро технологи", "Сонгинолог ургамал тариалах арга", "Байцаа тариалах арга" зэрэг 5 төрлийн гарын авлагыг олгосон.</p>	
5		<p>1.8. Жимс, жимсгэнэ, тарвасны тариалалтын талбайг тордон хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өрхүүд хашаандаа жимсний мод бут тариалах иргэдийг дэмжих;</p>	2018 - 2022		<p>Жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, өрхийн аж ахуйг дэмжих ажлын хүрээнд 30 иргэн, аж ахуйн нэгжид алим, монос, бөөрөлзгөнө, далан хальс, интоор, давжаа алим, үхрийн нүдний 400 ширхэг суулгацыг олгон, туршилтаар тариалсан. Тариалангийн талбайг элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор 8.65 км ойн зурвас байгуулсан.</p> <p>"Дорнын говийн тариаланчид" төрийн бус байгууллага, Дархан-Уул аймгийн ургамал газар тариалан сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хөрс судлалын лабораторитой хамтран аймгийн тариалангийн 97,6 га талбайд хөрсний чанар, төлөв байдалд агрохимийн шинжилгээ хийж, сорилын дүн, зөвлөмжийг тариаланчдад хүргүүлсэн. 14 сумын тариалангийн зориулалтаар ашиглагдаж буй талбайн хөрсний төлөв байдалд газар дээр нь очиж 14 удаа заавар зөвлөмж өгсөн. Хяналт шалгалтаар 14 сумын нийт 67 тариаланчийн 102 га талбайг хамруулсан.</p> <p>Дэлгэрэх суманд 3 га талбайд "Дэлгэрэх-100" цэцэрлэгт хүрээлэн, Мандах суманд 0,12 га талбайд "Дэнж"-ийн цэцэрлэгт хүрээлэн, Хатанбулаг суманд "Загийн овоо" гэх газарт 8 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулах зэрэг ажлуудын бэлтгэл ажлыг хангасан.</p>	100%
<p>2. Жимс, жимсгэнэ, тарвасны сорт шалгаруулах, говийн бүсэд тохиромжтой шинэ сортыг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран нутагшуулах, ган, хүйтэн болон өвчин хортонд тэсвэртэй, суулгацын хангамжийг нэмэгдүүлэх</p>						
6		<p>2.1. Эрдэм шинжилгээний байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийг түшиглэн жимс, жимсгэнийн төрөл, зүйлийн сорт нутагшуулах, анхдагч үржүүлэг, бойжуулга, суулгац</p>	2018 - 2022		<p>Агропаркийг түшиглэн газар тариалангийн чиглэлийн 10 удаагийн сургалтыг зохион байгуулж аймгийн төв болон сумдын 341 ногоочдыг хамруулсан.</p> <p>Дархан-Уул аймгийн Улсын газар тариалан судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн жимс жимсгэний секторын эрдэмтэдтэй хамтран Монгол оронд сүүлийн 5 жил нутагшуулж буй давжаа алим, бэсрэг алим, чавганы суулгацыг иргэдийн захиалгын дагуу татан авч</p>	100%

	үйлдвэрлэлийн ажлыг эрчимтэй явуулах			<p>намрын тариалалтын ажлыг зохион байгуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд нийт 35 ширхэг суулгацыг 6 иргэн, аж ахуй нэгж татан авч тариалан туршсан. Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих төсөл”-ийн 120 мянган долларын санхүүжилтээр аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэн жимс жимсгэний шинэ төрөл зүйлийг тариалан турших зорилгоор Сайншанд суманд 2 га талбайд өвөл, зуны хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулж, говийн бүсэд усан үзэм тариалах, судалгаа, шинжилгээний ажлыг эхлүүлэхээр бэлтгэлийг хангасан.</p> <p>Дорноговийн тарвас хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх улсын сорт сорилтын зөвлөлийн хурлаар аймагт тариалдаг Астарханьский сортыг нутагшсан сортоор батлуулж, аймгийн хэмжээнд анх удаа нутагшсан сорттой болсон. Сорт сорилтын ажлын хүрээнд тарвас, амтат гуаны 2, эртийн байцааны 1, сонгино 1, тарвасны 1, сармис 1, бууцай 1, гүзээлзэгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 9 төрлийн сортыг шинээр туршиж, амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар холбогдох газарт хүргүүлсэн.</p> <p>Мөн аймгийн төв Агропарктай хамтран “Монгол ногоо” төслөөс шинээр нэвтрүүлсэн төмс, хүнсний ногооны 23 сорт туршин шалгаруулах ажлын бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн. “Мөнх-Ашиг” хоршоо нь хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн ажлын хүрээнд сухай 100 кг төл, тагар сонгины 200 кг төл, тарвас 23 кг амтат гуаны 25,4 кг үр тус тус гарган авч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх “Монгол ногоо” төсөлд нийлүүлсэн.</p>	
7	2.2. Алим, чавга, интоор, чацаргана, үхрийн нүд, нэрс, гүзээлзэгэнэ, бөөрөлзөгөнө, хад зэрэг жимс, жимсгэнийн сортын суулгацыг тариалах иргэн, аж ахуйн нэгжид тодорхой хувийн хөнгөлөлттэй үнээр болон урт хугацаатай зээлээр олгох	2018 - 2022		<p>Дархан-Уул аймгийн Улсын газар тариалан судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн жимс жимсгэний секторын эрдэмтэдтэй хамтран Монгол оронд сүүлийн 5-н жил нутагшуулж буй давжаа алим, бэсрэг алим, чавганы суулгацыг иргэдийн захиалгын дагуу татан авч намрын тариалалтын ажлыг зохион байгуулсан.</p> <p>Жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, өрхийн аж ахуйг дэмжих ажлын хүрээнд 30 иргэн, аж ахуйн нэгжид алим, монос, бөөрөлзөгөнө, далан хальс, интор, давжаа алим, үхрийн нүдний 400 ширхэг суулгацыг олгон, туршилтаар тариалсан.</p>	100%
8	2.4. Орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд зохицсон сорт, дээжүүдийг	2018 - 2022		<p>Орон нутгийн онцлогт тохирсон тарвас, амтат гуаны 2, эртийн байцааны 1, сонгино 1, тарвасны 1, саримс 1, бууцай 1, гүзээлзэгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 9 төрлийн сортыг шинээр туршиж,</p>	70%

		турших.			амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар холбогдох газарт хүргүүлсэн.	
9		2.5. Орчин үеийн технологид суурилсан хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлж, дулаан нөхцөл шаарддаг усан үзэм, тоор, лийр, нимбэг, гүзээлзгэнэ, анар, улаан чавга зэрэг жимс, жимсгэнийг тариалан турших	2018 - 2022		Орон нутагт 5 иргэн аж ахуй нэгж гүзээлзгэний хүлэмжийг байгуулан тариалан туршиж 0,26 тн ургац хураан авч зах зээлд нийлүүлсэн.	50%
3. Жимс, жимсгэнэ, тарвасны тариалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг инноваци, дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны судалгаанд суурилуулан цогц байдлаар хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах						
10		3.1. Жимс жимсгэнийг хатаах, хөлдөөх, хуурайшуулах, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх дэвшилтэт технологи нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг цогцоор нь боловсруулах	2018 - 2022		"Оюун шанд" ХХК нь "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан"-гаас 25.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээл авч, "Зээг верень" бага оврын цех байгуулан, 6 сумын 13 цэгт борлуулалт хийдэг. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан төмс, хүнсний ногоо тариалах, ургуулах, хөрс боловсруулах, усалгаа, арчлах, бордоо ашиглах зөвлөмж, жимс, жимсгэнэ тариалах агротехнологийн зохистой дадлыг байршуулан, нийт 9350 иргэний /давхардсан тоогоор/ хандалт авсан бөгөөд 3 удаагийн цахим сургалтад 14 сумын ХААТ-н мэргэжилтэн бүх сумдад ажиллаж нийт 90 гаруй тариаланчид зөвлөгөө, гарын авлага өгч, мэдээллээр хангасан.	50%
11		3.2. Жимс, жимсгэнэ, тарвасны талбайд хамгаалах ойн зурвасыг байгуулж, тариалах агротехнологийг боловсруулах, тэдгээрийг хэвшүүлэх	2018 - 2022		Тариалангийн талбайг элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор 8.65 км ойн зурвас байгуулсан нь урьд оноос 40 хувиар өссөн.	50%
12		3.3. Орон нутгийн онцлогт тохирсон жимс,	2018 - 2022		Говийн бүсийн онцлогоос шалтгаалан газар тариалангийн үйлдвэрлэлд гүний ус татан ашигладаг тул хамгаалагдсан хөрсний	100%

		жимсгэнийн талбай, хүлэмжид усны зарцуулалт багатай усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх			<p>тариалалтад усны зарцуулалт багатай дуслын усалгааны системийг 100% нэвтрүүлсэн. Мөн 197,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр 15 га талбайд дуслын усалгааны систем нэвтрүүлсэн нь урьд оноос 68.1%-аар өссөн.</p> <p>“Мөрөөдлийн Говь” ХХК Эрдэнэ суманд хувийн хөрөнгө болох 23,0 сая төг, Сайншанд сумын бүлэг ногоочид нэгдэн хувийн хөрөнгө болон 20,0 сая төг, нийт 43,0 сая төгрөгөөр газар тариалангийн бүсэд гүн өрмийн худаг 2-г нэмэгдүүлсэн.</p> <p>Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд “Газар тариалан эрхлэлт ойжуулалтыг дэмжих сан”, “Хоршоо хөгжүүлэх сан”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас нийт 26 иргэн, ААН-д 341,2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж 960 м2 талбай бүхий дуслын усалтын системтэй зуны хүлэмжийг нэвтрүүлсэн.</p>	
13		3.4. Жимс, жимсгэнийн чиглэлээр ажиллаж байгаа судлаач, мэргэжилтэн, аж ахуй, үйлдвэрлэл эрхлэгч, сонирхогчдыг дэмжин дотоод, гадаадын мэргэжлийн сургалт, туршлага судлах арга хэмжээнд өргөн хамруулах, харилцан туршлага солилцох, тэдгээрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх	2018 - 2022		<p>БНХАУ-ын худалдааны яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Өвөр Монголын Өөртөө Засах Орны Тариалангийн их сургуулийн хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэний тариалангийн чиглэлээр зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх сургалтанд газар тариалан хариуцсан мэргэжилтнийг хамруулж Хөх хот, Бугат, Баяннуур аймгийн туршлага, Дорнод аймагт зохион байгуулагдсан “Хүнсний ногоо - жимс жимсгэнэ” улсын үзүүлэх сургалтад 2 ногоочныг хамруулан, өрхийн тариалан үйлдвэрлэлтэй танилцуулж, 21 аймгийн ногоочдоос харилцан туршлага судлуулсан.</p> <p>Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо, Европын холбооны SECiM төсөлтэй хамтран зохион байгуулсан “Хүлэмжийн нарийн ногоо тариалах агротехник ба хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоо” сэдэвт сургалтанд “Нарлаг” хүлэмжийн аж ахуй эрхлэгч “Мөнх ногоон” шанд ХХК-ын төлөөлөлийг хамруулсан.</p> <p>“Дэлхийн зөн Монгол” Олон Улсын Байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслийн хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх сумдын тариаланчдыг Улаанбаатар хотод 4 улирлын хүлэмжийн үйл ажиллагаатай танилцуулсан.</p>	100%
14		3.5. Байгаль цаг уурын нөхцөл ойролцоо хөрш орны жимс, жимсгэнийн судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэл эрхэлж байгаа	2018 - 2022		<p>Өвөр Монголын Өөртөө Засах Орны Бугат аймгийн байгаль орчин нөхөн сэргээх хороотой хамтын ажиллагааны хүрээнд сүүлийн 5 жил мод бутыг авч ногоон байгууламжид тариалж байна. Хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон Хөдөө аж ахуйн Их сургууль, Копиа төслийн санхүүжилтээр Өмнөговь аймагт зохион байгуулагдсан “Говийн</p>	100%

		байгууллага, аж ахуйн нэгж болон салбарын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч олон улсын байгууллагатай холбоо тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх;			бүсийн үр үйлдвэрлэл жимс жимсгэний суулгац үржүүлэг, тариалах арчлах технологи арчлалт” сэдэвт талбайн үзүүлэх сургалт, "Дэлхийн зөн Монгол" Олон Улсын Байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөл хэрэгжиж буй 3 сумдын газар тариалан эрхлэгч болон малчдын 45 төлөөллийг Төв аймгийн Баян-Чандмань сумын хүлэмжийн аж ахуй, техник тоног төхөөрөмж, тэжээлийн ургамал тариалахтай танилцуулан туршлага судлуулсан. Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол ногоо” төсөлтэй хамтран аймгийн 5 ногоочныг Төв аймгийн “Атрын шим” ХХК-д 3 хоногийн дадлага, сургалтад хамруулсан.	
15		3.6. Жимс, жимсгэнийн аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэгчдэд зориулсан мэргэжлийн зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэх, үйлдвэрлэгч, тариаланчдыг танхимын, талбайн, ажлын байран дахь сургалтад хамруулж, чадавхжуулах.	2018 - 2022		Чехийн хөгжлийн агентлагийн 300,0 орчим сая төгрөгийн санхүүжилтээр 2012 онд “Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлэн аймгийн төв “Агропарк” байгуулж, үйл ажиллагааг нь “Мөнх ашиг” хоршоонд хариуцуулсан. Сайншанд сумын Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнд Цэргийн ангийн 30 га талбайд Агропарк байгуулагдсан. Сайншанд сумын “Агропарк”-д Монгол Улсын зөвлөх агрономич ажиллаж орон нутгийн жимс, жимсгэний аж ахуй эрхлэгч, үйлдвэрлэгчдэд зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлж хэвшсэн ба тус онд танхимын болон талбайн, ажлын байрны сургалтад 52 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан. Аймгийн "Политехникийн коллеж"-тэй хамтран хүлэмжийн аж ахуй, жимс жимсгэнэ, фермерийн аж ахуйн ангийг шинээр нээн мэргэжилтэнүүд бэлтгэсэн. Одоогоор 25 суралцагч амжилттай төгсөж, 35 хүн элсэн суралцаж байна. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын МСҮТ-д 20 ногоочныг газар тариалангийн мэргэжлээр бэлтгэсэн.	100%
16		3.7. Жимс, жимсгэнэ, тарвасны бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах байгууллагууд болон төрийн өмчийн аж ахуйн нэгж) дэмжих нөхцөлийг бүрдүүлэх;	2018 - 2022		Цаг уур, амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор иргэд өрхийн тариалан эрхэлдэг учир жимс жимсгэнэ, тарвас борлуулалтад хүндрэлгүй улирлын чанартай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах олон нийтэд хүргэх арга хэмжээний хүрээнд газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 14 сумын давхардсан тоогоор 432 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо, нөхөрлөл, малчид оролцож бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан 296,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	90%
17		3.8. Жимс, жимсгэнэ, чацарганын болон үрийн	2018 - 2022		Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөн буйр аймгийн Хайлаар хотод зохион байгуулагдсан "Ногоон	70%

	холбоо зэрэг олон улсын байгууллагын туршлагаас суралцах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, мэргэжилтэн, судлаачдыг чадавхжуулах, бүтээгдэхүүнээ сурталчлах;				хөгжил" Олон Улсын үзэсгэлэн яармагт 5 хүний төлөөллийг хамруулж шинэ техник, технологи, үйлдвэрлэлийн тоног төхөөрмж, бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхон туршлага судлуулсан. Япон-Монголын хамтарсан Орон нутгийн онцлог бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаанд орон нутгийн үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч 20 иргэн, аж ахуй нэгжийн төлөөллийг цахимаар оролцуулан техник, технологи, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхон туршлага судлуулж хамтын түншлэлээ бэхжүүлсэн.	
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ						84,1

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Ж.НАРАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭНГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Е.УРАНЧИМЭГ